

Сонгино-хайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл

1954 оны Улаанбаатар хотын 4 хорооны нутаг дэвсгэрт төв түүхий эдийн баазын ажилчдын эрүүл мэндийн асуудлыг хариуцсан бага эмчийн салбар байгуулагдсан нь одоогийн эрүүл мэндийн нэгдлийн суурь тавигдсан.

1965 онд районы зохион байгуулалтад шилжсэнтэй холбогдуулан хүүхдийн түргэн тусламжийн хэсэг, эмэгтэйчүүдийн хэсэг хэвтүүлэн эмчлэх, тасаг бүхий Октябрийн нэгдсэн эмнэлэг байгуулагдсан.

1991 оноос хэсгүүдийг өрхийн эмнэлгийн зохион байгуулалтад оруулж эрүүл мэндийн төвүүд байгуулагдах үед одоогийн эрүүл мэндийн нэгдлийн байранд "Эрүүл мэндийн 14-р төв" нэртэйгээр зохион байгуулагдаж ерөнхий эмчээр Г.Цэрмаа ажиллаж байна.

1993 оны ЭМГ-н даргын 60-р тушаалаар 14-р төвийг татан буулгаж нийслэлийн Баянгол, Сонгино-хайрхан дүүргийн дундын үйлчилгээтэй "Октябрь" зөвлөх төв нэртэй зохион байгуулагдан үйл ажиллагаа явуулах байсан.

1997 оноос Нийслэлийн засаг даргын 1997 оны 01 дүгээр сарын А/08,06 тоот захирамжаар зөвлөх төвийг Эрүүл мэндийн нэгдэл болгон өргөжүүлж 100 ортой дотор, мэдрэлийн стационар дэлгэн 20 гаруй кабинет бүхий поликлиник, 0-16 насны хүүхдийн 24 цагийн үйлчилгээтэй түргэн тусламжийн салбар станц, паралиникийн тасаг бүхий бүтэцтэй 230 гаруй ажилчидтай 80 гаруй нарийн мэргэжлийн их эмчтэй үйл ажиллагаа явуулж, эхэлсэн. Эрүүл мэндийн зөвлөх төв болон Эрүүл мэндийн нэгдлийн даргаар 1993-2001 оны хооронд Д.Бат-Очир орлогч даргаар Д.Ганбаатар нар ажиллаж байлаа.

Энэ хугацаанд нийслэлийн засаг даргын 238 дугаар захирамжаар тус төвийн барилгын хойд урд корпусыг чөлөөлж түргэн тусламж, сүрьеэ гийн диспансацийг төвдөө татан авч, арьс өнгө, өрхийн эмч нар, бактериологи, биохимийн лаборатори, бусад нарийн мэргэжлийн кабинетууд, тасгуудыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн байрлуулж тохижуулан эмхлэн зохион байгуулж материаллаг бааз болон боловсон хүчний хувьд бэхэжсэн зөвлөх поликлиник болсон байна.

Эмнэлгийн бүтэц орон тоо, зохион байгуулалт, хүчин чадал

Сонгино хайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл нь СХД-ын 24 хорооны 23000 мянган гаруй хүн ам 47,0 мянган өрхийн нөхөрлөлд 109 өрхийн эмч, өрхийн 94 сувилагч дүүргийн хэмжээнд үйлчлэх хүүхдийн түргэн тусламжийн салбар станц, дотор мэс засал мэдрэл зэрэг нарийн мэргэжлийн болон бусад нарийн мэргэжлийн 51 кабинет СХДЭМН-н 342 ажилчид их эмч 105, сувилагч эмнэлгийн мэргэжилтэн 124/ байгаагаас сувилахуйн бакалавр зэрэгтэй 26/ лаборант 14 гэрлийн техникч 5 мэргэжлийн эм зүйч 2 байна.

НЭМГ-н даргын 2001 оны 88 дугаар тушаалын дагуу эрүүл мэндийн нэгдлийн үлгэрчилсэн дүрмийн хүрээнд эрүүл мэндийн нэгдлийн харьяалах байгууллагуудаас гадна 115 ортой дүүргийн нэгдсэн эмнэлэг, Жаргалант тосгоны эмнэлэг, өрхийн 25 эмнэлэг зэрэг хувийн хэвшлийн болон улсын ЭМБ-ын мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.